

## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### 2019 ОНЫ АЙМГИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД: БУА/2020/07-ГА

ЖДҮХС-гийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хийгдэж байгаа боловч ЖДҮХС-гаас зээлдэгчдэд тавьсан хяналт хангалтгүй үр дүн тодорхойгүй байна.

БУЛГАН АЙМАГ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр  
Утас: 70342580 Цахим хаяг: [Anknbayard@audit.gov.mn](mailto:Anknbayard@audit.gov.mn)  
Аудитын менежер Ж.Энхцоодол  
Утас: 70342716 Цахим хаяг: [Enkhtsoodoli@audit.gov.mn](mailto:Enkhtsoodoli@audit.gov.mn)  
Аудитор Б.Энхтөр  
Утас: 70342716 Цахим хаяг: [Enkhturb@audit.gov.mn](mailto:Enkhturb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой мэдээллийг дараах хаягаар авна уу.  
Цахим хуудас [www.audit.mn](http://www.audit.mn)

**АГУУЛГА**

Товчилсон үгийн жагсаалт.....	3
Хүснэгтийн товъёог.....	4
<u>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</u> .....	5
<b>БҮЛЭГ А. ЖДҮХС-гийн зээлийг хууль, журмын дагуу олгосон боловч аж ахуй нэгжийн гэрчилгээний үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл тохирохгүй “Амуун далай” ХХК, “НОЗА” ХХК байна</b> .....	6
<b>А.1. ЖДҮХС-гаас зээл хүссэн иргэн, аж ахуй нэгж нь тавигдах шаардлагыг ЖДҮХС-гаас урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийг хангаж ажилласан байна</b> .....	6
<b>А.2 Зээлээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ нь аймгийн нэгдсэн хөтөлбөр, үйл ажиллагааны чиглэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн байна</b> .....	7
<b>А.3. Олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж, ажлын байр бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ гэж үзэж дэмжсэн байна</b> .....	8
<b>БҮЛЭГ Б. ЖДҮХС-гийн зээлийг гэрээнд заасан хугацаанд төлж тайланг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.9. дэх “Зээлийн зарцуулалтын явц, байдлын талаарх тайланг санд 6 сар тутам ирүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй ЖДҮХС төсөл хөтөлбөрт хамрагдаж зээл авсан иргэн, ААН-ийн үйл ажиллагаа, зориулалтад хяналт хийж ажиллаагүй байна</b> .....	8
<b>Б.1. ЖДҮХС-гаас олгосон зээлийг 20 иргэн, аж ахуй нэгжийн гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаанд нь төлж байна</b> .....	9
<b>Б.2. ЖДҮХС нь олгосон зээлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй, ЖДҮ эрхлэгчид тайлан мэдээг хууль, журамд заасан хугацаанд ирүүлээгүй байна</b> .....	9
<b>ДҮГНЭЛТ</b> .....	11
<b>ЗӨВЛӨМЖ</b> .....	11

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
ХХОАТТХ	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
ХХААХҮЯ	Хүнс,хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сан
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ААН	Аж ахуй нэгж

**Хүснэгтийн товъёг**

<b>№</b>	<b>Тайлбар</b>	<b>Хуудасны дугаар</b>
<i>Хүснэгт 1</i>	<u>Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны чиглэл зөрүүтэй</u>	6
<i>Хүснэгт 2</i>	ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуй нэгжийг хүснэгт	7
<i>Хүснэгт 3</i>	Аймгийн 2019 оны ЖДҮХСангийн төслийн шинээр бий болсон ажлын байр	8
<i>Хүснэгт 4</i>	ЖДҮХС-ийн зээлийн эргэн төлөлтийг хүснэгт	9

<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “2019 оны аймгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зардлын гүйцэтгэл”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.</p>
<b>Аудитын зорилт</b>	Аймгийн орон нутгийн 2019 оны аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>• Аймгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийг зориулалтын дагуу ашигласан эсэх;</li><li>• ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгосон зээл үр дүнтэй байгаа эсэх</li><li>• ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийг гэрээний хугацаанд төлж, тайлан мэдээг хууль, журмын дагуу ирүүлж байгаа эсэх.</li></ul>
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	Аудитад аймаг, сумын ЖДҮ-ийг хөгжүүлэх сан, санхүүжилт хүссэн ААН, байгууллага, холбогдох байгууллагуудыг хамрууллаа.
<b>Аудитын хязгаарлалт</b> <b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	..... Аудитыг гүйцэтгэхэд гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Монгол улсын Төрийн аудитын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан төсөвт байгууллага ажлын хэсгийн ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж асуудлын шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа. Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Энхтөр гүйцэтгэлээ.
<b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b>	Аудитын төлөвлөгөөг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны дотор батлуулж талбарын ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдөр хүртэл гүйцэтгэж үе шатны хяналтыг хийлгэн холбогдох тайланг байгууллагуудад хүргүүлж ажиллалаа.

**Ерөнхий мэдээлэл:**

Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А-119 дүгээр тушаалын хавсралтаар журам баталжээ.

2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А-146 дугаар тушаалаар хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөл баталж, ХХААХҮС-ын 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А-156 дугаар тушаалаар зээл олгох эрх олгосноор ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах дэд хороог аймгийн Засаг даргын

2019 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн А/280 дугаар захирамжаар 8 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулсан байна.

ХХААХҮС-ын 2019 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн А-41 дүгээр тушаалаар Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангаас Булган аймгийн хэмжээнд 1.0 тэрбум төгрөгийн зээлийн эрхийг олгосон байна.

“ЖДҮХС-гаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ыг Засгийн газрын 2019 оны 190 дүгээр тогтоолоор баталсан хавсралтаар ЖДҮ-ийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг баталжээ.

Булган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 66 дугаар тогтоолоор “Булган аймагт үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх бодлого”-ыг 6 жилийн хугацаатай боловсруулж ЖДҮХС-гийн үйл ажиллагааг тус бодлогын хүрээнд хэрэгжүүлж ажиллаж байна.

**Бүлэг А. ЖДҮХС-гийн зээлийг хууль, журмын дагуу олгосон боловч аж ахуй нэгжийн гэрчилгээний үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл тохирохгүй “Амуун далай” ХХК, “НОЗА” ХХК байна.**

*Үндсэн үйл ажиллагааны чиглэл тохирохгүй аж ахуй нэгжийг хүснэгтээр харуулбал:*

№	Аж ахуй нэгж	Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл	Олгосон зээлийн дүн	Дэмжигдсэн төслийн үйл ажиллагааны чиглэл
1	НОЗА ХХК	Гадаад худалдаа	40,000,000	Гахайн аж ахуйн фермер
2	Амуу далай ХХК	Газар тариалан, барилгын засал чимэглэл, гадаад худалдаа	50,000,000	Сүү махны эрчимжсэн үхрийн фермер

Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл тохирохгүй төсөл сонгон шалгаруулсан байна.

**А.1. ЖДҮХС-гаас зээл хүссэн иргэн, аж ахуй нэгж нь тавигдах шаардлагыг ЖДҮХС-гаас урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийг хангаж ажилласан байна.**

2019 оны жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас зээл хүссэн 87 иргэн, ААН төсөл ирүүлснээс бичиг баримтын иж бүрдлийн шалгалтад тэнцсэн 49 төслийг дэд хорооны хурлаар хэлэлцэж 18 төслийг сонгон шалгаруулжээ.

Аймгийн ЖДҮХС-гийн дэд хорооны хуралдааны шийдвэрээр дэмжигдсэн төслийг аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/383 дугаар захирамжаар 11 аж ахуй нэгж, 7 иргэний төслийг 1.0 тэрбум төгрөгөөр баталж, банканд жагсаалтын дагуу хүргүүлжээ.

Дэд хорооны хурлаар дэмжигдсэн 18 төслийн 1.0 тэрбум төгрөгөөс банкны шаардлага хангахгүй, барьцаа хөрөнгө хүрэлцээгүйн улмаас 88.5 сая төгрөгийн санхүүжилт буцсан байна. Буцсан 88.5 сая төгрөгийн санхүүжилтэд дахин 5 төсөл хэлэлцэж 3 төслийг дэмжиж нийт 20 төслийн 960.0 сая төгрөг зарцуулжээ.

**А.2. Зээлээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ нь аймгийн нэгдсэн хөтөлбөр, үйл ажиллагааны чиглэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.**

“ЖДҮХС-гаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ыг Засгийн газрын 2019 оны 190 дүгээр тогтоолоор баталсан хавсралт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 66 дугаар тогтоолоор “Булган аймагт үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжүүлэх бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлж ажиллаж байна.

*ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуй нэгжийг хүснэгтээр харуулбал:*

№	Зээлдэгчийн нэр	Иргэн, ААН	Сумын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Баталсан санхүүжилт
1	Буман Сүхэс	ААН	Булган	Хиам, лаазалсан мах	60,000,000
2	Арвайн эхлэл	ААН	Булган	Талх, нарийн боов	100,000,000
3	Амуун далай	ААН	Хангал	Үхрийн фермер	50,000,000
4	Хангай пресс	ААН	Булган	Хэвлэл	45,000,000
5	Булган сор нэхий	ААН	Булган	Арьс, шир боловсруулах	20,000,000
6	Арвин ган бумба	ААН	Булган	Барилгын тоног төхөөрөмж	130,000,000
7	О.Лувсанжамц	Иргэн	Булган	Тавилгын үйлдвэрлэл	50,000,000
8	П.Наран	Иргэн	Булган	Гэрийн бүрээс оёдол	20,000,000
9	Ж.Цогтбаатар	Иргэн	Булган	Бетон хийц	45,000,000
10	Хос гурван хас	ААН	Булган	Талх, нарийн боов	59,500,000.0
11	И.Ханд	Иргэн	Булган	Төмс хүнсний ногоо	20,000,000
12	А.Мөнхцэцэг	Иргэн	Булган	Талх, нарийн боов	20,000,000
13	Их агт нутаг	ААН	Баян-Агт	Амралтын газар	28,500,000
14	Алтан хөрс	ААН	Баян-Агт	Тэжээлийн үйлдвэр	90,000,000
15	Ц.Бямбацэнд	Иргэн	Баян-Агт	Гутал үйлдвэрлэл	20,000,000
16	НОЗА	ААН	Орхон	Гахайн фермер аж ахуй	40,000,000
17	Б.Цэрэнбат	Иргэн	Хангал	Тахиа АА	60,000,000
18	Д.Бат-Өлзий	Иргэн	Хишиг-Өндөр	Гутал үйлдвэрлэл	50,000,000
19	Уул-Алтайд	ААН	Хутаг-Өндөр	Махны үхрийн фермер	30,000,000
20	Х.Болдбаатар	Иргэн	Хишиг-Өндөр	Махны чиглэлийн үхрийн фермер	22,000,000.0
<b>Нийт дүн</b>					<b>960,000,000</b>

Аймгийн хэмжээнд 2019 онд 7 сумын 20 иргэн, аж ахуй нэгжид 17 чиглэлээр хөнгөлөлттэй зээл олгосон. Зээл олгосон чиглэлийг салбараар нь авч үзвэл:

- ✓ Мах махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах – 5
- ✓ Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл – 3
- ✓ Арьс шир боловсруулах – 1
- ✓ Барилгын материал үйлдвэрлэл – 2
- ✓ Мал амьтны тэжээл үйлдвэрлэл – 1
- ✓ Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэл – 3
- ✓ Сав баглаа боодол үйлдвэрлэл – 1
- ✓ Төмс, хүнсний ногоо – 1
- ✓ Туслах аж ахуй – 1
- ✓ Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл – 1
- ✓ Бусад – 1 гэсэн чиглэлээр төслийг сонгон шалгаруулжээ.

**А.3. Олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж, ажлын байр бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ гэж үзэж дэмжсэн байна.**

ЖДҮХС нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2, 14.6 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтыг үндэслэн экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор төслийг сонгон шалгаруулсан байна.

*Аймгийн 2019 оны ЖДҮХСангийн төслийн шинээр бий болсон ажлын байрны орон тоо*

№	Зээлдэгчийн нэр	Иргэн, ААН	Реестрын дугаар	Олгосон зээл /сая/	Байнгын орон тоо	Шинэ ажлын орон тоо
1	Буман Сүхэс	ААН	3191125	60	8	2
2	Арвайн эхлэл	ААН	3191524	100	5	20
3	Алтан хөрс	ААН	2007312	90	2	9
4	Амуун далай	ААН	3194221	50	4	5
5	Хангай пресс	ААН	3194957	45	6	0
6	Булган сор нэхий	ААН	3197018	20	1	5
7	НОЗА	ААН	4393198	40	4	8
8	Арвин ган бумба	ААН	3196755	130	5	3
9	Уул-Алтайд	ААН	2007215	30	2	15
10	Хос гурван хас	ААН	3188396	59.5	3	11
11	Их агт нутаг	ААН	3185907	28.5	3	7
12	О.Лувсанжамц	Иргэн	Г393072235	50	3	7
13	Д.Бат-Өлзий	Иргэн	ГМ68090316	50	3	4
14	П.Наран	Иргэн	ГЮ64090867	20	3	1
15	Б.Цэрэнбат	Иргэн	НЮ83042975	60	2	3
16	Ж.Цогтбаатар	Иргэн	ГП83062917	45	3	4
17	Ц.Бямбацэнд	Иргэн	ГА73022867	20	2	2
18	Х.Болдбаатар	Иргэн	ГМ66101616	22	3	0
19	И.Ханд	Иргэн	ГЮ59020703	20	1	13
20	А.Мөнхцэцэг	Иргэн	ТЕ76020408	20	4	4
Нийт дүн				<b>960</b>	<b>67</b>	<b>123</b>

Энэхүү 20 төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр 123 хүн шинээр ажлын байртай болж амьжиргаа нь дээшилнэ гэж үзэж дэмжсэн байна.

**Бүлэг Б. ЖДҮХС-гийн зээлийг гэрээнд заасан хугацаанд төлж тайланг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.9. дэх “Зээлийн зарцуулалтын явц, байдлын талаарх тайланг санд 6 сар тутам ирүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, ХХААХҮЯ-наас хэрэгжүүлж буй ЖДҮХС төсөл хөтөлбөрт хамрагдаж зээл авсан иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагаа, зориулалтад хяналт хийж ажиллаагүй байна.**

**Б.1. ЖДҮХС-гаас олгосон зээлийг 20 иргэн, аж ахуй нэгжийн гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаанд нь төлж байна.**

2020 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар зээлийн эргэн төлөлтийг үзэхэд 2 иргэн зээлээ огт төлж эхлээгүй байна.

**ЖДҮХС-ийн зээлийн эргэн төлөлтийг хүснэгтээр харуулбал**

№	Зээлдэгчийн нэр	Иргэн, ААН	Регистрийн дугаар	Зээлийн хүү /сар/	Олгосон зээл /сая/	Зээлийн үлдэгдэл	Олгосон огноо	Дуусах огноо
1	Буман Сүхэс	ААН	3191125	0.45	60	58.9	2019.10.23	2024.10.23
2	Арвайн эхлэл	ААН	3191524	0.45	100	96.3	2019.10.02	2024.10.02
3	Алтан хөрс	ААН	2007312	0.45	90	86.6	2019.09.25	2024.09.25
4	Амуун далай	ААН	3194221	0.45	50	48.1	2019.09.19	2024.09.19
5	Хангай пресс	ААН	3194957	0.45	45	43.3	2019.10.03	2024.10.03
6	Булган сор нэхий	ААН	3197018	0.45	20	19.6	2019.10.02	2024.10.02
7	НОЗА	ААН	4393198	0.45	40	38.5	2019.10.23	2024.10.23
8	Арвин ган бумба	ААН	3196755	0.45	130	86.2	2019.08.12	2024.08.12
9	Уул-Алтайд	ААН	2007215	0.45	30	28.9	2019.09.26	2024.09.26
10	Хос гурван хас	ААН	3188396	0.45	59.5	58.3	2019.10.04	2024.10.04
11	Их агт нутаг	ААН	3185907	0.45	28.5	28.4	2019.12.13	2024.12.13
12	О.Лувсанжамц	Иргэн	ГЗ93072235	0.45	50	50	2019.10.28	2024.10.28
13	Д.Бат-Өлзий	Иргэн	ГМ68090316	0.45	50	48.03	2019.09.16	2024.09.16
14	П.Наран	Иргэн	ГЮ64090867	0.45	20	18.9	2019.09.06	2024.09.06
15	Б.Цэрэнбат	Иргэн	НЮ83042975	0.45	60	57.7	2019.09.17	2024.09.17
16	Ж.Цогтбаатар	Иргэн	ГП83062917	0.45	45	33.5	2019.10.07	2024.10.07
17	Ц.Бямбацэнд	Иргэн	ГА73022867	0.45	20	19.2	2019.09.25	2024.09.25
18	Х.Болдбаатар	Иргэн	ГМ66101616	0.45	22	21.2	2019.09.16	2024.09.16
19	И.Ханд	Иргэн	ГЮ59020703	0.45	20	20	2019.12.13	2024.12.13
20	А.Мөнхцэцэг	Иргэн	ТЕ76020408	0.45	20	19.9	2019.12.19	2024.12.19
<b>Нийт дүн</b>					<b>960</b>	<b>881.53</b>		

2019 онд ЖДҮХС-гаас нийт 960.0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээл олгосноос эргэн төлөлтөөр 78.5 сая төгрөгийн төлөлт хийгдсэн байна.

**Б.2. ЖДҮХС нь олгосон зээлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй, ЖДҮ эрхлэгчид тайлан мэдээг хууль, журамд заасан хугацаанд ирүүлээгүй байна.**

2019 онд ЖДҮХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлтөд банк хяналт тавин ажиллаж байна.

ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл авсан 20 иргэн, аж ахуй нэгжээс хуульд заасан хугацаанд үйл ажиллагааны тайлан мэдээг шаардаж аваагүй, зээлийн зориулалт, ажлын байр бий болгосон зэргийн үр дүнд хяналт хийгдээгүй байна.

ЖДҮХС-гийн зээл олгосон тайлан мэдээг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.9. дэх "Зээлийн зарцуулалтын явц, байдлын талаарх тайланг санд 6 сар тутам ирүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, сангийн төсөл хөтөлбөрт хамрагдаж зээл авсан иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагаа, зориулалтад Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 3 иргэн, 5 аж ахуй нэгжид хяналт хийж бусад 12 иргэн, аж ахуй нэгжийн зээлийн зориулалтад хяналт хийж тайлан мэдээ гаргаж ажиллаагүй байна.

"Арвайн эхлэл" ХХК нь талх, нарийн боовны цехээ өргөтгөж 2 давхар болгох, тоног төхөөрөмж нэмж авах чиглэлээр төслөөс зээл авсан боловч ажлын байраа

өргөжүүлээгүй, тоног төхөөрөмж нэмж аваагүй байгаа нь санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан, үр дүн тодорхойгүй байна.



### ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хөнгөлөлттэй зээл авсан иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьсан тайлан мэдээ байхгүй, үр дүнтэй хэрэгжиж байгаа, хэдэн ажлын байр шинээр бий болгосон нь тодорхойгүй байна.
- ХХААГ-ын ЖДҮ-ийн асуудал хариуцсан мэргэжилтний шаардлага хангахгүй тайлан мэдээг нөхөж авсан боловч зээл авсан иргэн, аж ахуй нэгжийн төслийн хэрэгжилтэд “ЖДҮХС-гаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын дагуу хяналт тавиагүй байна.
- ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл авсан иргэн, аж ахуй нэгжээс үйл ажиллагааны тайлан мэдээг хууль журмын дагуу аваагүй байна.

### ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэд хүргүүлж байна. Үүнд:

- ✓ “ЖДҮХС-гаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын дагуу хяналт хийж, хууль, журмын дагуу тайлан мэдээг гаргуулж нэгтгэж, үр дүнг тооцож ажиллах.
- ✓ Хөнгөлөлттэй зээлийг зориулалт бусаар ашиглаж байгаа иргэн, аж ахуй нэгжийг хяналт шалгалтаар тогтоож төсөлд тусгасан чиглэлийн дагуу үндсэн үйл ажиллагааг хууль, журамд нийцсэн арга хэмжээ авах.

### МЭДЭГДЭЛ:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж хэрэгжилт, үр дүнг 2021 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР  
Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

Б.ЭНХТӨР

ЖДҮХС-аас 2019 онд урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох салбар. Үүнд:

- ✓ Арьс шир боловсруулах
- ✓ Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах
- ✓ Барилгын материал үйлдвэрлэх
- ✓ Хог хаягдал, дахин боловсруулах
- ✓ Мал, амьтны тэжээл үйлдвэрлэх
- ✓ Ноос, ноолуур боловсруулах
- ✓ Мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах
- ✓ Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- ✓ Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- ✓ Сав баглаа боодол үйлдвэрлэх
- ✓ Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах
- ✓ Туслах аж ахуй
- ✓ Гурил гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- ✓ Бусад

ЖДҮХС-аас 2019 онд урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох чиглэл. Үүнд:

- ✓ Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- ✓ 5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон
- ✓ Мал аж ахуйн гаралтай түүхийн эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо-Засвар хоршоо
- ✓ Баяжуулсан болон органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- ✓ Инновацийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх
- ✓ Импортыг орлох шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- ✓ Эрчимжсэн аж ахуй
- ✓ Шинэ техник, технологи нэвтрүүлэх

